



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН 2023 ОНЫ
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

1

САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2

АРИЛЖААНЫ МЭДЭЭ

3

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

4

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

5

ДҮГНЭЛТ



Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
3. ХЭ-Хувьцаа эзэмшигч
4. ХНХ-Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хүснэгт, дүрслэлийн жагсаалт

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн хаяг, байршлын мэдээлэл

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Дүрслэл 2. ХЭ, ХНХ-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах, салбар, төлөөлөгчийн газар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт

Дүрслэл 3. ҮМҮЧЭТХЭАЭ иргэдийн байршлын мэдээлэл

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ



Хураангуй

Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд:

Тайлант хугацааны байдлаар Хороо нэр бүхий 52 хуулийн этгээд, 428 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 5-аар нэмэгдэж, иргэдийн тоо 37-оор буурсан үзүүлэлт юм.

Тайлант онд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх тухай нийт 12 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид:

Тайлант онд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 3.2 тн үнэт металлыг 433,783,765.9 мянган төгрөгөөр худалдан авч, 3.3 тн үнэт металлыг 461,145,251.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 2.7 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 2.5 дахин буурсан үзүүлэлт юм.

Мөн онд 2.2 тн алтыг 430,711,079.2 мянган төгрөгөөр худалдан авч, 2.3 тонн алтыг 457,320,251.7 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 3.9 дахин, худалдсан алтны хэмжээ 3.6 дахин бууржээ.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь 1,063.5 кг мөнгийг 3,072,686.7 мянган төгрөгөөр худалдан авч, 1,042.6 кг мөнгийг 3,824,729.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 5.8 дахин, худалдсан мөнгөний хэмжээ 11.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Хяналт шалгалт:

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 480 иргэн, хуулийн этгээдээс 1,054 арилжааны мэдээ, 146 санхүүгийн тайлан ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.

Тайлант онд Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 8 хуулийн этгээд, 181 иргэний үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.


Нэр бүхий 106 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, үүнээс 43 иргэний тусгай зөвшөөрлийг сэргээсэн бөгөөд 75 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Тайлант хугацааны байдлаар Хороо нэр бүхий 52 хуулийн этгээд, 428 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 5-аар нэмэгдэж, иргэдийн тоо 37-оор буурсан үзүүлэлт юм. Зохицуулалттай этгээдүүдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан дүрслэл 1-д үзүүлэв.




Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Тайлант онд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх тухай нийт 12 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн. Эдгээр хүсэлтийг төрлөөр нь ангилан дүрслэл 2-т үзүүлэв.



Дүрслэл 2. ХЭ, ХНХ-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах, салбар, төлөөлөгчийн газар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт



Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 75.2 хувь буюу 322 нь Улаанбаатар хотод, 24.8 хувь буюу 106 иргэн нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийг байршлаар нь ангилан хүснэгт 1-д үзүүлэв.

| Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд | Үнэт металл болон үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд | Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд | Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд | Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд |
|-------------------------------|--|--|--|--|
| Сүхбаатар | 4 | 7 | 4 | 13 |
| Хан-Уул | 1 | 8 | 1 | 13 |
| Баянзүрх | 3 | 7 | 8 | 3 |
| Чингэлтэй | 45 | 164 | 29 | 15 |
| Баянгол | 7 | 17 | 3 | 5 |
| Сонгинохайрхан | 4 | 9 | 1 | 2 |
| Орон нутаг | 22 | 8 | 76 | 1 |

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн хаяг, байршлын мэдээлэл

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 106 ҮМҮЧЭТХЭАЭ иргэдийг байршлаар нь ангилан дүрслэл 3-т үзүүлэв.




Дүрслэл 3. ҮМҮЧЭТХЭАЭ иргэдийн байршлын мэдээлэл

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн 75.5 хувь буюу 80 иргэн нь Баянхонгор, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байгаа бол үлдсэн 24.5 хувь буюу 26 иргэн нь Өмнөговь, Ховд, Говь-Алтай, Увс, Дорноговь, Өвөрхангай, Дорнод, Орхон, Хэнтий аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө


Тайлант онд 52 хуулийн этгээд нь 84 хувьцаа эзэмшигчийн 10,013,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 5-аар нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)


Хувь нийлүүлсэн хөрөнгийн 53.2 хувь буюу 5,324,506.1 мянган төгрөгийг дотоодын хөрөнгө оруулалт, 46.8 хувь буюу 4,688,923.0 мянган төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалтын эзэлж буй хувийг улсаар нь ангилан дүрслэл 5-д үзүүлэв.



Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц


Тусгай зөвшөөрөлтэй 52 хуулийн этгээдийн 33 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 13 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 6 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 6-д үзүүлэв.



Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц


Арилжааны мэдээ

Тайлант онд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 3.2 тн үнэт металлыг 433,783,765.9 мянган төгрөгөөр худалдан авч, 3.3 тн үнэт металлыг 461,145,251.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 2.7 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 2.5 дахин буурсан үзүүлэлт юм.




Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 2.2 тн алтыг 430,711,079.2 мянган төгрөгөөр худалдан авч, 2.3 тонн алтыг 457,320,251.7 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 3.9 дахин, худалдсан алтны хэмжээ 3.6 дахин буурсан үзүүлэлт юм.



Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Тайлант онд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 1,063.5 кг мөнгийг 3,072,686.7 мянган төгрөгөөр худалдан авч, 1,042.6 кг мөнгийг 3,824,729.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 5.8 дахин, худалдсан мөнгөний хэмжээ 11.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ




Мөн зохицуулалттай этгээдүүд нь өссөн дүнгээр 20,833,315.1 мянган төгрөгийн үнийн дүн бүхий үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдан авсан бол 33,425,117.8 мянган төгрөгийн үнийн дүн бүхий үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдан борлуулсан байна.

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022 он | Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ | 2023 он | Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ |
|--|---------------------|--------------------------------|---------------------|--------------------------------|
| ХӨРӨНГӨ | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 7,371,108.1 | 13% | 15,657,020.7 | 24.4% |
| Дансны авлага | 4,367,349.7 | 8% | 2,095,248.6 | 3.3% |
| Татвар, НДШ – ийн авлага | 610,968.2 | 1% | 446,963.8 | 0.7% |
| Бусад авлага | 1,085,702.4 | 2% | 1,348,651.8 | 2.1% |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 1,085,702.4 | 2% | 0,0 | 0% |
| Бараа материал | 24,303,528.1 | 42% | 25,711,976.1 | 40.1% |
| Урьдчилж төлсөн зардал/гооцоо | 3,787,761.3 | 7% | 4,652,925.6 | 7.3% |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 247,604.9 | 0% | 451,245.6 | 0.7% |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 2,260,613.4 | 4% | 1,756,445.3 | 2.7% |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 44,034,636.1 | 76% | 52,120,377.5 | 81.3% |
| Үндсэн хөрөнгө | 12,258,005.2 | 21% | 11,031,334.9 | 17.2% |
| Биет бус хөрөнгө | 295,908.9 | 1% | 540,067.3 | 0.8% |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 407,374.1 | 1% | 407,374.1 | 0.6% |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 574,432.7 | 1% | - | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 37,100.1 | 0% | 34,450.1 | 0.1% |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 434,057.0 | 1% | - | - |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 14,006,878.0 | 24% | 12,013,226.4 | 18.7% |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 58,041,514.1 | 100% | 64,133,603.9 | 100% |
| Дансны өглөг | 18,222,769.5 | 31% | 15,316,397.9 | 23.9% |
| Цалин, татвар, НДШ-ийн өглөг | 2,286,906.7 | 4% | 2,350,997.3 | 3.7% |
| Банкны богино хугацаат зээл | 2,650,319.6 | 5% | 2,256,109.0 | 3.5% |
| Ногдол ашгийн өглөг | 750,000.0 | 1% | 202,500.0 | 0.3% |
| Хүүний өглөг | 792,619.4 | 1% | 889,225.0 | 1.4% |
| Урьдчилж орсон орлого | 5,418,477.7 | 9% | 1,819,135.0 | 2.8% |
| Нөөц /өр төлбөр/ | 14,508.6 | 0% | 16,307.7 | 0% |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 5,340,546.6 | 9% | 6,565,886.9 | 10.2% |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 35,576,148.1 | 61% | 29,416,558.8 | 45.9% |
| Урт хугацаат зээл | 5,639,025.4 | 10% | 6,894,064.6 | 10.8% |
| Хойшлогдсон татварын өр | 3,718.1 | 0% | 6,241.7 | - |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 737,888.5 | 1% | - | - |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 6,380,632.0 | 11% | 6,900,306.3 | 10.8% |
| Өр төлбөрийн нийт дүн | 41,956,780.1 | 72% | 36,316,865.0 | 56.6% |
| Өмч | 9,404,419.1 | 16% | 10,013,429.1 | 15.6% |
| - хувийн | 9,404,419.1 | 16% | 10,013,429.1 | 15.6% |
| Нэмж төлөгдсөн капитал | 2,278,232.1 | 4% | 2,278,232.1 | 3.6% |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 321,263.9 | 1% | 288,263.9 | 0.4% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 2,919,013.1 | 5% | 1,591,581.3 | 2.5% |
| Хуримтлагдсан ашиг | 1,161,797.6 | 2% | 13,645,232.6 | 21.3% |
| Эздийн өмчийн дүн | 16,084,734.0 | 28% | 27,816,738.9 | 43.4% |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 58,041,514.1 | 100% | 64,133,603.9 | 100% |

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт





2022 он

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нэгтгэлд тайлант хугацааны үзүүлэлтээр 44 хуулийн этгээд, өмнөх улирлын тайлангийн үзүүлэлтээр 3 хуулийн этгээд нийт 47 хуулийн этгээд 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа. Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 75 хувьцаа эзэмшигчийн 9,404,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 58,041,514.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



2023 он

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нэгтгэлд тайлант хугацааны үзүүлэлтээр 43 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 9 хуулийн этгээд нийт 52 хуулийн этгээд 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа. ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 84 хувьцаа эзэмшигчийн 10,013,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 64,133,603.9 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



Зохицуулалттай этгээдүүдийн ХНХ, нийт хөрөнгө, хуримтлагдсан ашгийн нийт дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдлаар өөрчлөлт орсон байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ



Нийт хөрөнгийн хэмжээ



Хуримтлагдсан ашгийн хэмжээ



Тайлант онд зохицуулалттай этгээдүүд нь 64,133,603.9 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Нийт хөрөнгийн 81.3 хувь буюу 52,120,377.5 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бол 18.7 хувь буюу 12,013,226.4 мянган төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн өр төлбөр ба эздийн өмчийн дүн 64,133,603.9 мянган төгрөгт хүрсэн бөгөөд үүний 56.6 хувь буюу 36,316,865.0 мянган төгрөгийг өр төлбөрийн нийт дүн, 43.4 хувь буюу 27,816,738.9 мянган төгрөгийг эздийн өмчийн дүн тус тус эзэлж байна.

Тайлант онд зохицуулалттай этгээдүүд нь 13,645,232.6 мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

Нийт орлого

63,787,691.9 мянган төгрөг

Борлуулалтын орлого

62,939,791.6 мянган төгрөг

Нийт зардал

51,729,480.0 мянган төгрөг

Цэвэр ашиг 12,058,211.9
мянган төгрөг

Үзүүлэлтүүд

2023.III

| | |
|---------------------------------|---------------------|
| Нийт орлого | 100% |
| Борлуулалтын орлого (цэвэр) | 98.7% |
| Бусад орлого | 1.3% |
| Нийт зардал | 100% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 65.9% |
| Борлуулалт, маркетингийн зардал | 12.8% |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 12.8% |
| Санхүүгийн зардал | 2.2% |
| Бусад зардал | 1.9% |
| Орлогын татварын зардал | 4% |
| Бусад гарз | 0.4% |
| Тайлант үеийн цэвэр ашиг | 12,058,211.9 |

* 2023 онд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 63,787,691.9 мянган төгрөгийн нийт орлоготой, 51,729,480.0 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

* Зохицуулалттай этгээдүүд нь тайлант онд 12,058,211.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.


Хүснэгт 3. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

* Нийт орлогын 98.7 хувийг борлуулалтын орлого, 1.3 хувийг бусад орлого эзэлж байгаа бол нийт зардлын 65.9 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 12.8 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 12.8 хувийг борлуулалт маркетингийн зардал, үлдсэн 8.5 хувийг бусад зардлууд тус тус эзэлж байна.

Хууль, эрх зүйн орчныг сайжруулах

Хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан арилжаа эрхлэгчдээс ирүүлэх санхүүгийн тайлан болон арилжааны мэдээний мастер файлыг боловсруулж, тайлан нэгтгэлийн Фина системд мета датаг өрж, журмын хэрэгжилтийг хангуулсан.

Тус журмаар ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь улирал бүрийн дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор холбогдох тайлан мэдээг Хороонд тайлагнах нөхцөл бүрдсэн.

| | | |
|---|--|--|
|  <p>ЦАХИМ ТАЙЛАН</p> | <p>Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч</p> <p>/Улирал бүр/</p> | <ul style="list-style-type: none"> • Арилжааны мэдээ • МАСТЕР ФАЙЛ ТАТАХ • Санхүүгийн тайлан • МАСТЕР ФАЙЛ ТАТАХ |
|---|--|--|

Хамтын ажиллагаа



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийг хэлэлцэх, оролцогч байгууллагуудын ойлголтыг нэгтгэх зорилгоор нэр бүхий 4 төрийн байгууллага, (Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар) болон Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоодын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулав.



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт оролцов.



САНГИЙН ЯАМ

Сангийн яамнаас зохион байгуулсан "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ)-ийн сургалтад хамрагдаж, холбогдох саналыг 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр хүргүүлсэн.

Уулзалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль бус уул уурхайн эрх зүйн зохицуулалтын талаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох нэр бүхий төрийн байгууллагууд, Азийн сангийн хамтарсан уулзалтад оролцож, санал солилцсон.

Монголбанкнаас 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Швейцарь улсын үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр Argor Heraeus SA-с комплаенс хариуцсан төлөөлөгчид болон Монголбанк, Монголын арилжааны банкнуудын төлөөлөгчидтэй "Хариуцлагатай алт олборлолт болон Монголд алт олборлох үйл ажиллагаа, гарал үүслийн баталгаажуулалт" уулзалтад оролцож, санал солилцов.

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн мэргэжлийн холбоо болон "Санхүүгийн боловсролын зангилаа" ГҮТББ-тай хамтран үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 10 гаруй төлөөллүүдэд "Комплаенс-мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах" сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.



"Хууль бус уул уурхай, асуудал шийдэл" хэлэлцүүлэгт оролцов.

Сургалт



Тайланд онд 11 удаагийн сургалтаар ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 177 иргэн, 43 хуулийн этгээдийг сургалтад хамруулж, хичээл заав.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулах ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн.



"Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний холбоо" ГҮТББ-тай хамтран салбарын мэргэжилтэнд эрх олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, салбарын 92 оролцогчийг хамруулсан.



Иргэд, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Mongolian jewellery and metal-expo 2023” арга хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ҮМҮЧЭТХЭАЭ-ийн зохицуулалт, хууль, эрх зүйн орчны талаарх зөвлөгөө, мэдээллийг 500 орчим иргэн, хуулийн этгээдэд хүргэж ажиллав.

Монгол улсад Стандарт, хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жил, Сорьцын хяналтын газрын 60 жилийн ойг тохиолдуулан иргэд олон нийтэд санхүүгийн боловсролыг олгох, төрийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн.





ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН АНХААРАЛД



ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУВЬ ХҮН, БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдээр үйлчлүүлэх.



ЗӨВХӨН ТӨГРӨГӨӨР ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх" гэж заасны дагуу гадаад валютаар төлбөр тооцоог гүйцэтгэхгүй, зарлан сурталчлахгүй байх.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар бол олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэйд тооцогддог салбаруудын нэг юм.

**ИЙМД САЛБАРЫН ЗОХИЦУУЛАГЧ
БАЙГУУЛЛАГААС ДАРААХ СЭРЭМЖЛҮҮЛГИЙГ
ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ХҮРГҮҮЛЖ БАЙНА**

☎ 51-262607, 51-262604
🌐 www.frc.mn
📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, 15160



Алтын сорьцын тэмдэг



Мөнгөний сорьцын тэмдэг

"Эрдэнийн чулууны гэрчилгээ"-тэй үнэт эдлэл худалдан авах.

ЗАЛИЛАН МЭХЛЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НБ

А. Цахим худалдаанд оролцож, үнэт эдлэл худалдан авахдаа эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, эрдэнийн чулууны гэрчилгээ, сорьцын баталгааны тэмдгийг тулган шалгах.



Б. Иргэдийн гар дээрээс үнэт эдлэл худалдан авахгүй байх.



ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН АНХААРАЛД



Та үнэт эдлэл, үнэт чулуунаар хийсэн бүтээгдэхүүн худалдан авахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ, СУРГАЛТАД ХАМРАГДСАН** иргэн, хуулийн этгээдээр үйлчлүүлээрэй.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ ШАЛГАХ:

1. Доорх QR кодыг уншуулан тусгай зөвшөөрөлтэй этгээдийн мэдээллийг шалгах боломжтой.



2. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн мэдээлэлтэй Санхүүгийн зохицуулах хорооны www.frc.mn цахим хуудасны "Зохицуулалтын салбар" – "Үнэт металл, үнэт эдлэл" – "Тусгай зөвшөөрөл эзэмшигчид" цэснээс танилцах боломжтой.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь "МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ" хуульд заасны дагуу "Мэдээлэл үүргийг этгээдэд хямаарах тул тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн байж болохгүй этгээдийн талаарх мэдээллийг info@frc.mn цахим шуудан болон доорх утсаар мэдээлнэ үү.

📍 Санхүүгийн зохицуулах хороо
🌐 www.frc.mn
📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, 15160

☎ 51-262607, 51-262604

Хорооноос хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу, иргэд, олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, иргэнээр үйлчлүүлэхийг уриалсан, таних тэмдэг бүхий QR кодтой постерыг хэвлэн нийтэлсэн.

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 52 хуулийн этгээд, 428 иргэдээс 1,054 арилжааны мэдээ, 146 санхүүгийн тайлан ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.




Зөвлөмж (хуулийн этгээд)

49



ТЗ-ийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэл

206



УБАШ

4

Тайлант онд Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 181 иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.



Зөвлөмж (иргэд)

29

Газар дээрх хяналт шалгалтад хамрагдсан 181 иргэний 68.5 хувь буюу 124 иргэн нь Улаанбаатар хотод, 31.5 хувь буюу 57 иргэн нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 4 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдэд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.



Мөн Өмнөговь, Дархан-Уул аймгуудад ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэв.



Тайлант хугацааны байдлаар Хороо нэр бүхий 52 хуулийн этгээд, 428 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна.

Тайлант онд Хорооноос нэр бүхий 75 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, үүнээс 43 иргэний тусгай зөвшөөрлийг сэргээсэн.

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ 52 хуулийн этгээд нь 84 хувьцаа эзэмшигчийн 10,013,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 5-аар нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 52 хуулийн этгээдийн 10,013,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 53.2 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 46.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант онд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 3.2 тн үнэт металлыг 433,783,765.9 мянган төгрөгөөр худалдан авч, 3.3 тн үнэт металлыг 461,145,251.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 2.7 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 2.5 дахин буурсан үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 2.2 тн алтыг 430,711,079.2 мянган төгрөгөөр худалдан авч, 2.3 тонн алтыг 457,320,251.7 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 3.9 дахин, худалдсан алтны хэмжээ 3.6 дахин буурсан үзүүлэлт юм.

Тайлант онд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 1,063.5 кг мөнгийг 3,072,686.7 мянган төгрөгөөр худалдан авч, 1,042.6 кг мөнгийг 3,824,729.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 5.8 дахин, худалдсан мөнгөний хэмжээ 11.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд зохицуулалттай этгээдүүд нь 64,133,603.9 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлжээ. Нийт хөрөнгийн 81.3 хувь буюу 52,120,377.5 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бол 18.7 хувь буюу 12,013,226.4 мянган төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 63,787,691.9 мянган төгрөгийн нийт орлоготой, 51,729,480.0 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

Зохицуулалттай этгээдүүд нь тайлант үед 12,058,211.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Дүгнэлт

Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 52 хуулийн этгээд, 428 иргэдээс 196 санхүүгийн тайлан, 268 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.

Тайлант онд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 13,645,232.6 мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

Тайлант онд Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 41 иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.

